



ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 8/63

Чингис хот

Ж.Саруултөгсийг Төрийн албаны зөвлөлийн  
Хэнтий аймаг дахь салбар зөвлөлийн орон тооны  
нарийн бичгийн даргаар томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4, 33.5, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.2, 65 дугаар зүйлийн 65.6, 57 дугаар зүйлийн 57.2, 57.2.2 дахь заалт, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” 275 дугаар тогтоолын хавсралт, “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 262 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн албаны зөвлөлийн Хэнтий аймаг дахь салбар зөвлөлийн орон тооны нарийн бичгийн даргын албан тушаалд Жаахүүгийн Саруултөгсийг 2020 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс томилсугай.

2. Ж.Саруултөгсийн сарын үндсэн цалинг Т3-10-4 шатлалаар тогтоон, 1035204 /нэг сая гучин таван мянга хоёр зуун дөрөв/ төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 15, зэрэг дэвийн нэмэгдлийг 24 хувиар тус тус тооцож олгохыг нягтлан бодогч /Э.Ариунтунгалаг/-д зөвшөөрсүгэй.

3. Төрийн албаны зөвлөлийн Хэнтий аймаг дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ж.Саруултөгсөд үүрэг болгосугай.

4. Ж.Саруултөгсөд томилогдоноос хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Ж.Гантулга/-т гаргаж өгөх үүрэгтэйг сануулсугай.

ДАРГА

Ж.ГАНБААТАР

231030295